


Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж УТҮГ-ын 2024 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 11/6 дугаар албан бичгийн хавсралт



Тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариу №1

“Улаанбаатар хотын төмөр зам доогуур авто замын нүхэн гарц барих” төслийн техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн ажлын даалгавартай холбоотой тендерийн тодруулгад дараах байдлаар хариу хүргүүлэв. Үүнд:

Асуулт №1
Хариулт: Хяналтын багийн гишүүдэд тавигдах шаардлагын хүснэгтийн 9-т заасан албан тушаалтан нь шаардлага хангасан аль нэг инженер байж болох бөгөөд хос мэргэжилтэй бол давуу тал болно.
Асуулт №2
Хариулт: Хяналтын багийн гишүүдэд тавигдах шаардлагын хүснэгтийн 5-т заасан албан тушаалтан нь шаардлага хангасан аль нэг инженер байж болно.
Асуулт №3
Хариулт: Ажлын даалгаварт заасан шаардлагыг хангасан барилгын инженер эсвэл барилгын бүтээц эдлэлийн инженер байна.
Асуулт №4, №6
Хариулт: Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой зайлшгүй шаардагдах машин, тоног төхөөрөмжийг гэрээт ажил эхэлж дуусах хүртэл захиалагчийг хангаж, техникийн туслалцаа үзүүлнэ. Тухай зардлыг төсөвт өртөгт тооцож ирүүлнэ. Ажлын зориулалттай туулах чадвартай автомашин - 1 ш <ul style="list-style-type: none">• Зориулалт: Суудлын• Үйлдвэрлэсэн он: 2020 оноос хойш• Суудлын тоо: 7-оос дээш• Моторын багтаамж: 2500сс-аас багагүй• Жолооны хүрдний байрлал: Зүүн• Хаалганы тоо: 5 Өндөр хүчин чадал бүхий компьютер – 2 ш <ul style="list-style-type: none">• Core i9 12900-аас дээш• Ram 64GB-аас багагүй• Дэлгэц: 27 инч-ээс багагүй (4 ш) Итгэмжлэгдсэн лаборатори ажиллуулах. /Иж бүрэн – 1ш/
Асуулт №5

Хариулт: Ажлын даалгаврын 6.1.1-т заасны дагуу инженер техникийн ажилчдын мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалт зохион байгуулна. Сургалтын зардлыг төсөвт тооцож ирүүлнэ.

Асуулт №7

Хариулт: Ажлын даалгаварт заасан төлөвлөлт, судалгаа, тооцоолол хийх чадвартай, тухайн чиглэлээр олон улсад ажилласан туршлагатай гадаад эсвэл дотоодын хуулийн этгээд, эсвэл хувь хүн байж болно.

Асуулт №8

Хариулт: Тендерт оролцогч этгээд санхүүгийн задаргааг нарийвчлан тооцож ирүүлнэ. Ажлын даалгаварт заасан сургалт зохион байгуулах зардал нь нийт санхүүжилтийн 8%-аас багагүй байна. Бусад зардлуудын хувьд нийт санхүүжилтэд эзлэх хувь өөр өөр байж болно.

“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах
нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ